



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тайшир сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/125/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр
	Утас: 70483413      Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a>
	Аудитын менежер:      Д.Эрдэнэчимэг
	Утас: 70484055      Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a>
	Аудитор:      П. Ганцолмон
	Утас: 70157405      Цахим хаяг: <a href="mailto:uliastaivanaudit@gmail.com">uliastaivanaudit@gmail.com</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Материаллаг байдал.....	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	10
3.8 Аудитын гол асуудал.....	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
4. Аудитын илрүүлэлт.....	12
4.1 Залруулсан алдаа.....	12
4.2 Төлбөрийн акт.....	12
4.3 Албан шаардлага.....	12
4.4 Зөвлөмж.....	13
4.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	13

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.25

№

119

танай

-ны №

-т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тайшир сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тайшир сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

07920305

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.ТҮВШИНБАЯР

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>43,773,050.63</b>	<b>45,304,294.63</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>43,773,050.63</b>	<b>45,304,294.63</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>943,880.00</b>	<b>1,999,880.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	943,880.00	943,880.00
35130	Эм боох материал	0.00	1,056,000.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>42,829,170.63</b>	<b>43,304,414.63</b>
35410	Бичиг хэргийн материал	1,014,000.00	1,014,000.00
35420	Аж ахуйн материал	14,286,857.63	14,535,857.63
35450	Барилгын засварын материал	50,000.00	50,000.00
35460	Хүнсний материал	2,780,430.00	1,856,674.00
35470	Бусад хангамжийн материал	24,697,883.00	25,847,883.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>916,315,254.46</b>	<b>867,038,332.53</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>916,315,254.46</b>	<b>867,038,332.53</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>912,096,504.46</b>	<b>862,894,582.53</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	920,603,478.00	857,985,158.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(65,423,083.13)	(38,132,673.60)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	48,574,300.00	44,353,420.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(16,611,117.85)	(21,728,267.27)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,718,822.23	36,564,820.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,765,894.79)	(16,147,874.60)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,566,000.00	1,283,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,566,000.00)	(1,283,000.00)
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>4,218,750.00</b>	<b>4,143,750.00</b>
39301	Програм хангамж	520,000.00	520,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(301,250.00)	(376,250.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	4,000,000.00	4,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>960,088,305.09</b>	<b>912,342,627.16</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>960,088,305.09</b>	<b>912,342,627.16</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>960,088,305.09</b>	<b>912,342,627.16</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	35,355,003.77	35,355,003.77
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>897,522,764.20</b>	<b>876,987,623.39</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	901,169,014.61	924,733,301.32
51220	Тайлант үеийн үр дүн	(3,646,250.41)	(47,745,677.93)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	27,210,537.12	0.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>960,088,305.09</b>	<b>912,342,627.16</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>216,247,600.00</b>	<b>190,897,700.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>11,890,500.00</b>	<b>1,765,600.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>11,890,500.00</b>	<b>1,765,600.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>11,890,500.00</b>	<b>0.00</b>
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	11,890,500.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	230,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	1,535,600.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>204,357,100.00</b>	<b>189,132,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>147,184,000.00</b>	<b>141,652,100.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	147,184,000.00	141,652,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>40,000.00</b>	<b>80,000.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	40,000.00	80,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>57,133,100.00</b>	<b>47,400,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	57,133,100.00	47,400,000.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>219,893,850.41</b>	<b>218,135,833.40</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>219,893,850.41</b>	<b>218,135,833.40</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>185,629,992.22</b>	<b>208,821,096.58</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>109,608,614.00</b>	<b>111,996,632.00</b>
210101	Үндсэн цалин	100,750,783.00	102,530,715.00
210104	Урамшуулал	8,857,831.00	9,465,917.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>13,553,207.81</b>	<b>14,300,154.78</b>
210201	Тэтгэврийн даатгал	10,487,428.81	10,330,007.09
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	1,059,202.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	880,229.00	847,382.32
210204	Ажилгүйдлийн даатгал	192,192.00	192,309.07
210205	Эрүүл мэндийн даатгал	1,993,358.00	1,871,253.33
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>39,487,270.00</b>	<b>44,563,466.40</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,283,337.00	901,826.40
210302	Түлш, халаалт	38,203,933.00	43,661,640.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,727,894.41</b>	<b>1,801,040.00</b>
210401	Бичиг хэрэг	340,000.00	322,800.00
210402	Тээвэр, шатахуун	268,450.00	306,640.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	250,000.00	300,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	51,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	387,000.00	820,200.00
210408	Бараа материал акт алсны зардал	3,282,444.41	0.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>4,979,860.00</b>	<b>4,944,926.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	162,500.00	76,500.00
210502	Хоол, хүнс	4,567,360.00	4,868,426.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	250,000.00	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>855,500.00</b>	<b>1,220,000.00</b>
210604	Урсгал засвар	855,500.00	1,220,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>56,000.00</b>	<b>0.00</b>
210702	Дотоод албан томилолт	56,000.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>544,000.00</b>	<b>995,500.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	347,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11,817,646.00</b>	<b>28,999,377.40</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,817,646.00	28,999,377.40
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>34,263,858.19</b>	<b>9,314,736.82</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>780,100.00</b>	<b>800,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	780,100.00	800,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>16,790,330.00</b>	<b>1,336,533.60</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,790,330.00	1,336,533.60
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>16,693,428.19</b>	<b>7,178,203.22</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,693,428.19	7,178,203.22
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>(3,646,250.41)</b>	<b>(27,238,133.40)</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>20,507,544.53</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	20,507,544.53
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(3,646,250.41)</b>	<b>(47,745,677.93)</b>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	35,355,003.77	27,210,537.12	901,169,014.61	963,734,555.50
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	35,355,003.77	27,210,537.12	901,169,014.61	963,734,555.50
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(3,646,250.41)	(3,646,250.41)
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	35,355,003.77	27,210,537.12	897,522,764.20	960,088,305.09
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	35,355,003.77	27,210,537.12	897,522,764.20	960,088,305.09
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	27,210,537.12	27,210,537.12
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	35,355,003.77	27,210,537.12	924,733,301.32	987,298,842.21
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	(27,210,537.12)	0.00	(27,210,537.12)
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(47,745,677.93)	(47,745,677.93)
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	35,355,003.77	0.00	876,987,623.39	912,342,627.16

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>204,357,100.00</b>	<b>189,132,100.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>204,357,100.00</b>	<b>189,132,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>147,184,000.00</b>	<b>141,652,100.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	147,184,000.00	141,652,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>40,000.00</b>	<b>80,000.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	40,000.00	80,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>57,133,100.00</b>	<b>47,400,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	57,133,100.00	47,400,000.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>204,357,100.00</b>	<b>189,132,100.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>204,357,100.00</b>	<b>189,132,100.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>170,093,241.81</b>	<b>179,817,363.18</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>109,608,614.00</b>	<b>111,996,632.00</b>
210101	Үндсэн цалин	100,750,783.00	102,530,715.00
210104	Урамшуулал	8,857,831.00	9,465,917.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>13,553,207.81</b>	<b>14,300,154.78</b>
210201	Тэтгэврийн даатгал	10,487,428.81	10,330,007.09
210202	Тэтгэмжийн даатгал	0	1,059,202.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	880,229.00	847,382.32
210204	Ажилгүйдлийн даатгал	192,192.00	192,309.07
210205	Эрүүл мэндийн даатгал	1,993,358.00	1,871,253.33
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>39,487,270.00</b>	<b>44,563,466.40</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,283,337.00	901,826.40
210302	Тулш, халаалт	38,203,933.00	43,661,640.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,688,450.00</b>	<b>1,438,440.00</b>
210401	Бичиг хэрэг	340,000.00	322,800.00
210402	Тээвэр, шатахуун	268,450.00	306,640.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	250,000.00	300,000.00
210404	Нөм, хэвлэл	50,000.00	0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	159,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	580,000.00	349,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>4,240,200.00</b>	<b>4,591,170.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	162,500.00	646,500.00
210502	Хоол, хүнс	3,827,700.00	3,944,670.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	250,000.00	0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>855,500.00</b>	<b>1,500,000.00</b>
210604	Урсгал засвар	855,500.00	1,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>56,000.00</b>	<b>0</b>
210702	Дотоод албан томилолт	56,000.00	0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>544,000.00</b>	<b>1,127,500.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0	479,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>60,000.00</b>	<b>300,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	60,000.00	300,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>34,263,858.19</b>	<b>9,314,736.82</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>780,100.00</b>	<b>800,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, цагнал урамшуулал	780,100.00	800,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>16,790,330.00</b>	<b>1,336,533.60</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,790,330.00	1,336,533.60
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>16,693,428.19</b>	<b>7,178,203.22</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,693,428.19	7,178,203.22

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>189,052,100.00</b>	<b>180,537,363.18</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>189,052,100.00</b>	<b>180,537,363.18</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>188,252,100.00</b>	<b>179,737,363.18</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>117,140,000.00</b>	<b>111,996,632.00</b>
210101	Үндсэн цалин	107,526,000.00	102,530,715.00
210104	Урамшуулал	9,614,000.00	9,465,917.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>14,513,000.00</b>	<b>14,300,154.78</b>
210201	Тэтгэврийн даатгал	10,644,000.00	10,330,007.09
210202	Тэтгэмжийн даатгал	968,000.00	1,059,202.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	774,000.00	847,382.32
210204	Ажилгүйдлийн даатгал	194,000.00	192,309.07
210205	Эрүүл мэндийн даатгал	1,933,000.00	1,871,253.33
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>45,900,000.00</b>	<b>44,563,466.40</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,000,000.00	901,826.40
210302	Түлш, халаалт	43,662,400.00	43,661,640.00
210303	Цэвэр, бохир ус	237,600.00	0.00
210304	Байрны түрээс	0.00	0.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,406,700.00</b>	<b>1,358,440.00</b>
210401	Бичиг хэрэг	243,700.00	242,800.00
210402	Тээвэр, шатахуун	307,000.00	306,640.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	346,000.00	300,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	160,000.00	159,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	350,000.00	349,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>6,354,400.00</b>	<b>4,591,170.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	650,000.00	646,500.00
210502	Хоол, хүнс	5,704,400.00	3,944,670.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,500,000.00</b>	<b>1,500,000.00</b>
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,138,000.00</b>	<b>1,127,500.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	490,000.00	479,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	648,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>300,000.00</b>	<b>300,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00	300,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>800,000.00</b>	<b>800,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>800,000.00</b>	<b>800,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	800,000.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>189,052,100.00</b>	<b>180,537,363.18</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>141,652,100.00</b>	<b>134,473,896.78</b>
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	141,652,100.00	134,473,896.78
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>47,400,000.00</b>	<b>46,063,466.40</b>
320001	Орон нутгийн төсвөөс	47,400,000.00	46,063,466.40

Аудитын код ГАА-2022/125/-НА-СТА-ТШЗ



### 3.Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тайшир сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Аудитын “Улиастай ван аудит” ХХК-ийн аудитор П.Ганцолмон гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Тайшир сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тайшир сумын Хүүхдийн цэцэрлэг нь: Хүүхдийн сурах үйлийг дэмжиж сургалтын амжилт чанар, хөгжил төлөвшилтийг сайжруулан хоцрогдолгүй сургах, эрүүл аж төрөх амьдралын зөв хэв маяг, бие даан суралцах чадвар эзэмшүүлэхэд бүх талын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, хүний нөөцийн тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлж ажиллах зорилго дэвшүүлж ажилласан.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахаар даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитаас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Аудитын код ГАА-2022/125/-НА-СТА-ТШЗ



Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тайшир сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 204.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 4.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.2 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 218.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 4.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.4 сая төгрөгөөр тогтогдлоо.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тайшир сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4.9 хувиар буюу 47.7 сая төгрөгөөр буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 45.3 сая төгрөг болж 1.5 сая төгрөгөөр өссөн нь эм боох, аж ахуйн, бусад хангамжийн материал нэмэгдсэнтэй холбоотой.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 7.6 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 7.0 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 944.7 сая төгрөг болж 71.3 сая төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр хөрөнгө бэлтгээгүй, үнэ төлбөргүйгээр 0.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэн, 71.5 сая төгрөгийн хөрөнгийг акталсантай холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 912.3 сая төгрөг болж 47.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 11.7 хувиар буюу 25.3 сая төгрөгөөр буурсан нь санхүүжилт болон үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлоготой холбоотой.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү 27.2 сая төгрөгийг хаасан бичилт хийгдсэн нь дахин үнэлэгдсэн хөрөнгө акталсантай холбоотой. Тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 876.9 сая төгрөг болсон байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 254.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 65.9 сая төгрөгөөр бууруулж, 189.0 сая төгрөгөөр баталжээ.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 7 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 189.0 сая төгрөгийн төсөв баталснаас 141.6 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс 47.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 141.5 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 47.4 сая төгрөг нийт 189.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 180.7 сая төгрөгийг зарцуулж 7.1 сая төгрөгийг улсын төсөвт, 1.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 180.5 сая төгрөг буюу 95.4 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 5.1 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 0.2 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардлыг 1.3 сая төгрөгөөр, норматив зардлыг 1.7 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 0.08 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 38 мэдээллээс цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 123.0 сая төгрөгийн 1 орлогын гүйлгээ, 10.9 сая төгрөгийн 2 зарлагын гүйлгээг хугацаа хоцорч мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчлийг арилгах 1 заалт бүхий албан шаардлага хүргүүлснийг биелүүлсэн.

#### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараа жилийн аудитаар:

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан,
2. Бараа материалын үлдэгдлийг тулган баталгаажуулах
3. Төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй гэж үзлээ.

### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 47.5 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 47.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1 заалт бүхий зөвлөмжийг хүргүүллээ.

#### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулга хийгдээгүй

#### 4.2 Төлбөрийн акт

Тогтоосон төлбөрийн акт байхгүй.

#### 4.3 Албан шаардлага

- Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байгаа нь: Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар" 43 дугаар тогтоолын 1.1-д "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсвөөс, арга

Аудитын код ГАА-2022/125/-НА-СТА-ТШЗ

хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал, болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөж хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

- Татварын тодорхойлолтоор 0.07 сая төгрөгийн дутуу төлөлт татварын цахим системд бүртгэлтэй байгаа нь "Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалттай нийцэхгүй оршин байх батламж мэдэгдлийг хангаагүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- Аж ахуйн нэгж, байгууллагаас 0.76 сая төгрөгийн и-баримтгүй худалдан авалт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэж заасныг зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- Тайлант онд 47.0 сая төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бичсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Аж ахуй нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккурэл сууриар хөтөлнө" заалт, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3. Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ, 14.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх, 14.3.2.журналд бичих, 14.3.3.дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх, 14.3.4.ажил, гүйлгээний мэдээ гаргах, 14.3.5.санхүүгийн тайлан гаргах. УСНББОУС1, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

#### 4.4 Зөвлөмж

Аудитаар илэрсэн 1 алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Аудитын код ГАА-2022/125/-НА-СТА-ТШЗ



- 1.1. Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 38 мэдээллээс цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 123.0 сая төгрөгийн 1 орлогын гүйлгээ, 10.9 сая төгрөгийн 2 зарлагын гүйлгээг хугацаа хоцорч мэдээлсэн.
- 1.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах
- 1.3. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/сая төгрөгөөр/							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тайшир сумын хүүхдийн цэцэрлэг	5	47.5	0	0	0	0	4	47.5	1	0